

СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024-2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг боловсронгуй болгох” гэж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 10 дугаар 07-ны өдрийн 159 дүгээр захирамжид “Стандартчилал, тохирлын үнэлгээний эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх” талаар, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Нэг Улс-Нэгдсэн стандарт” хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж, нийт 33 салбар, үйл ажиллагаанд шинэ стандарт нэвтрүүлэхээр тус тус заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5-ын 1 дүгээр үе шат (2021-2030)-ны 4-т “Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ.”, Зорилт 4.4-ийн 2 үе шат (2021-2030)-ны 3-т “Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчилнө.” гэж тус тус заасан.

Монгол Улсад өнөөгийн байдлаар 2017 онд батлагдсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, тухайн салбарын стандартыг батлан хэрэгжүүлэхээр заасан 71 хууль, нийт 6657 стандарт хэрэгжиж байгаа ч түүнийг иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөхгүй байгаагаас шалтгаалан хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, бүтээгдэхүүний аюулгүй байдал алдагдаж, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна.

Одоо мөрдөгдөж буй хуулийн 4.1.2 дахь заалтад стандартыг “сонгон хэрэглэх баримт бичиг” гэж томъёолсон нь иргэн, хуулийн этгээдэд стандарт дагаж мөрдөх үүрэггүй гэсэн буруу ойлголтыг төрүүлж байгааг тодорхой томъёолох шаардлагатай байна.

Монгол Улсын Шадар сайдын тушаалаар 2022 онд барилга, эрүүл мэнд, хүнс, аялал жуулчлалын салбарын 2004 стандартад үзлэг хийж олон улсын жишигт нийцсэн эсэхийг судлахад 809 стандартыг хэвээр, 57 стандартыг шинээр боловсруулах, 159 стандартыг хүчингүй болгох, 1036 стандартыг олон улс, бүс нутгийн жишигт нийцүүлэн шинэчлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.

Дүгнэлт гарснаас хойш 3 жилийн хугацаа өнгөрөхөд 204 буюу үзлэгт хамрагдсан өөрчилбөл зохих нийт стандартын 20 хүрэхгүй хувийг шинэчлэн баталж, үлдсэн 80 орчим хувийг шинэчлээгүй өнөөдрийг хүрчээ.

Энэ нь эрүүл мэнд, барилга, хүнс, аялал жуулчлалын салбар дэлхийн хөгжил дэвшил, технологи, инновацаас хоцорч, дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, худалдаан дахь саад тотгорыг арилгахад сөргөөр нөлөөлж байна.

Тохирлын үнэлгээний итгэмжлэлд хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд нөлөөлөхүйц бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ хамрагдахгүй байгаа нь нийгмийн эрүүл мэндийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Тухайлбал, эрүүл мэндийн чиглэлийн төр, хувийн хэвшлийн 400 орчим лаборатори үйл ажиллагаа явуулж байгаагаас 35 лаборатори стандартын үзүүлэлт шаардлагыг хангаж итгэмжлэгдсэн байна.

2024-2025 онд уул уурхай, төмөрлөг, зам, тээвэр, байгаль орчин, аялал жуулчлал, шуудан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хэмжил зүй, хүүхдийн

хөгжил, цаг уур, орчин, тамхи, тамхин бүтээгдэхүүний салбарын нийт 2293 стандартад үзлэг хийж, олон улсын жишигт нийцсэн эсэхийг судлахад 169 стандартыг хэвээр үлдээх, 171 стандартыг шинээр боловсруулах, 333 стандартыг хянаж шинэчлэх 164 стандартыг хүчингүйд тооцох дүгнэлт гарсан байна.

Дүгнэлт гарсанаас хойш 26 стандартыг шинээр, 81 стандартыг хянаж шинэчлэн, 58 стандартыг хүчингүй болгосон байна.

Мөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 61 хуулийн 87 заалтаар салбар бүр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд салбарын хууль тогтоомждоо лабораторийн талаар харилцан адилгүй тодорхойлсон бөгөөд лаборатори бүр харилцан мэдээлэл солилцох, үр дүнг нэгтгэн дүгнэх, хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн нэгдсэн мэдээллийн систем хөгжүүлээгүй байна. Иймд лабораторийн харилцааны суурь эрх зүйн үндсийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Монгол Улсын хэмжээнд нийт 224 лаборатори (төрийн 54, хувийн 170) үйл ажиллагаа явуулж байгаагаас 174 нь итгэмжлэгдсэн ба худалдаалагдаж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг (эмийн болон пестицидийн үлдэгдэл, микотоксин, хүнд металл болон бусад бохирдуулагч) бүрэн шинжилж чадахгүй байгаа нь хүнсний аюулгүй байдал алдагдах түвшинд хүрч, хүнсээр дамжих өвчлөлийн тохиолдлын тоо ихсэж, улмаар хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх болсныг харуулж байна.

Стандартын хэрэгжилтийг хангуулах, хянах тогтолцооны нэг хэсэг нь лаборатори боловч өнөөгийн байдлаар үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сорилын лабораториудын барилга, байгууламж, хүчин чадал, тоног төхөөрөмж, урвалж бодисын хангалт, хүний нөөцийн чадавх муу байгаагаас бүх салбарын лабораторийн бодлого, тогтолцоо алдагдаж, стандартын хэрэгжилтийг хангах, хянах боломжгүйд хүрсэнийг төрийн бодлогоор дэмжих зайлшгүй шаардлагатай байна.

Үндэсний итгэмжлэлийн төвөөс итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагууд нь аж ахуйн нэгж байгууллагуудад стандартын баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгож байгаа боловч гэрчилгээтэй аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл буурахгүй, хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлэхгүй байх асуудал газар авсаар байгааг Үндэсний итгэмжлэлийн байгууллагын хараат бус, ил тод, хариуцлагатай байдлыг хангах, түүнд тавих хяналтын тодорхой механизмыг энэхүү хуулиар нарийвчлан хуульчилж, итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлснээр бууруулна.

Монгол Улсад анх Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийг 1994 онд, Стандартчилал, тохирлын үнэлгээний хуулийг 2003 онд, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг 2017 онд тус тус баталжээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 159 дүгээр захирамжийн дагуу стандартчиллын эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хүрээнд нийслэл, 21 аймгийн иргэд, аж ахуй нэгж, төр, захиргааны байгууллага, мэргэжлийн холбоодыг оролцуулан зохион байгуулсан 60 гаруй хэлэлцүүлгийн үр дүн болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээний дүгнэлт, холбогдох судалгаагаар энэ хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн.

Дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгоор Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 оноос хойш боловсруулж хуулийн төслийг Үндэсний хэмжээнд нэгдсэн хэлэлцүүлэг 3 удаа, салбарын хэмжээнд 60 удаа зохион байгуулсан ба мөн “Стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин” хэлэлцүүлгийг Төрийн ордонд 2025 оны 02 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд, барилга, эрүүл мэнд, хүнсний салбарын стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин, итгэмжлэл болон тохирлын үнэлгээний байгууллагын эрх зүйн орчин сэдэвт хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 20,000 гаруй оролцогчийг хамруулж, санал, зөвлөмжийг тусгасан.

Цаашид сонгосон стандартыг үзүүлэлт шаардлагын хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгох замаар стандартыг хэрэгжүүлдэг соёл, хандлагыг төлөвшүүлэх, үндэсний хяналт, зохицуулалтын болон лабораторийн тогтолцоо бий болгох, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн байгууллагын статусыг тодорхой болгох шаардлагатай гэж Ажлын хэсэг, мэргэжлийн оролцогчид, эрдэмтэн судлаачид дүгнэсэн.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хуулийн 50-аас дээш хувьд өөрчлөлт орохоор байгаа тул шинэчилсэн найруулгын төсөл боловсрууллаа.

Энэ хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний судалгаа, хэрэгжилтийн талаарх нарийвчилсан зохицуулалт, нийцлийн судалгаа, Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд хэрхэн нийцэж байгаа талаарх судалгаа, лабораторийн эрх зүйн орчныг тодорхой болгох хэрэгцээ шаардлагын талаар судалгаа, Стандартын хөгжлийн сан, стандартын байгууллагын ажилтны нийгмийн баталгаа зэрэг нь бусад хууль тогтоомжтой давхардаж байх, зарим харилцаа буюу итгэмжлэлийн үйл ажиллагаа, лабораторийн шинжээчийн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөлд хамаарах, Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулах шаардлагатай гэж дүгнэснийг тус тус хэлэлцэн ихэнх саналыг хүлээн авч, хуулийн төслийг ахин сайжруулсан болно.

Ингэхдээ оролцогч талуудын эрх үүргийг тодорхой болгох замаар стандартын хэрэгжилтийг хангуулахад онцгой анхаарсан.

Хуулийн төсөлд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэх зохицуулалтыг өөрчилж, стандартыг иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөхөөр заасан. Стандартаар дамжуулан салбарын үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог бий болгоход хуулийн төслийн гол үзэл баримтлал чиглэж байна.

Стандарт, техникийн зохицуулалтыг дагаж мөрдөх, бүтээгдэхүүн, үйлчилгээг баталгаажуулалтад хамруулах, худалдаан дахь тарифын бус саад тотгорыг арилгах, лабораторийн шаталсан тогтолцоо бий болгох хэм хэмжээ бүхий хуулийн төслийг хэлэлцэн баталснаар стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллага, түүний хяналт, зохицуулалтын тогтолцоо бүрдэж, салбар дундын уялдаа хангагдаж, иргэд, олон нийтийн оролцоо нэмэгдэнэ.

Түүнчлэн олон улсын болон бүс нутгийн стандартыг хүлээн зөвшөөрөх, хэрэглэх, нутагшуулж, стандартыг хэрэгжүүлэх хяналт, зохицуулалтын тогтолцоо боловсронгуй болсноор дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандарт олон улсад зөвшөөрөгдөж, гадаад худалдаа, экспортыг хөнгөвчлөх нөхцөл сайжирна гэж үзэж байна.

Энэ хуулийн төсөл батлагдсанаар экспорт, импортын барааг тохирлын үнэлгээний байгууллагын тохирлын гэрчилгээ, нотолгоонд үндэслэх байдал дээшилж, улмаар тохирлын баталгаатай бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх нөхцөл бүрдэж, дотоодын бүтээгдэхүүн олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ гэж тооцож байна.

Мөн төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар дэвшилтэт технологи бүхий лаборатори байгуулах, лабораторийн нэгдсэн тогтолцоо бий болох нөхцөл бүрдэнэ.

Дэлхийн улс орнууд стандартын цахимжуулалт, дижитал шилжилтийн дараагийн шат болох хиймэл оюун ухаан руу шилжиж байна. Стандарт, хэмжил зүйн салбар сүүлийн нэг жилийн хугацаанд 26 ажил, үйлчилгээг цахимжуулсан бөгөөд цахимжилт, мэдээллийн сангийн эрх зүйн зохицуулалтыг мөн хуулийн төсөлд тусгасан.

Стандарт, тохирлын үнэлгээний салбарт цахимжуулалт, мэдээллийн санг нэвтрүүлснээр энэхүү үйл ажиллагаанд оролцогчид мэдээллийн санд мэдээлэл оруулах, мэдээллийг харилцан ашиглах байдлыг нэмэгдүүлж, хил, гааль, төрийн хяналт шалгалтын салбарт мэдээллийн санд үндэслэсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэхээр зорьж байна.

Стандарт, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн үйл ажиллагааг цахимжуулснаар хил, гаалийн мэдээлэл, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг хилийн хорио цээрийн хяналттай нэвтрүүлэх, төрийн үйлчилгээ хялбарших, улмаар авлигын эрсдэлийг бууруулах боломж бүрдэх юм.

Цаашид стандарт, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн үйл ажиллагаагаар дамжуулан салбар бүрийн шилдэг технологи, инновацийн шинэчлэлтийг нэвтрүүлж, хяналт зохицуулалтын тогтолцоог сайжруулж, иргэдийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, гадаад, дотоод худалдааны эргэлтийг сайжруулж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд голлох хувь нэмрийг оруулах учиртай.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах гол зохицуулалтыг тусгасан болно. Үүнд:

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Энэ бүлгээр хуулийн зорилт, хууль тогтоомжийн тогтолцоо, стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим болон хуулийн нэр томьёоны тодорхойлолтыг тусгасан.

Хоёрдугаар бүлэг. Стандартчилал

Энэ бүлгээр стандартчиллын зорилго, стандартчиллын баримт бичгийн төрөл, үндэсний болон байгууллагын стандарт, олон улс, бүс нутгийн болон гадаад улсын стандартыг хэрэглэх нөхцөл, стандартчиллын техникийн хорооны бүрэн эрх, стандартыг хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулсан.

- Олон улс, бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, гадаад улсын стандартын монгол хэл дээрх албан ёсны орчуулгыг бүртгүүлсний үндсэн дээр хэрэглэх;

- Бүртгүүлэн хэрэглэж байгаа стандартыг 18 сарын дотор үндэсний стандартаар батлуулах;
- Дотоодын худалдаанд нийлүүлэхгүй, экспортлох бүтээгдэхүүнтэй холбоотой бүртгүүлэн хэрэгдэх стандартыг үндэсний стандартаар батлуулахгүй байж болох;
- Гадаадын хөрөнгө оруулалттай, нэг удаагийн шинжтэй томоохон бүтээн байгуулалтад хөрөнгө оруулагч талын стандартыг талууд харилцан тохиролцож, гэрээний нөхцөл болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэглэж болох;
- Үндэсний стандартыг мэдээллийн нэгдсэн санд нээлттэй үнэ төлбөргүй байршуулах талаар тусгасан.

Гуравдугаар бүлэг. Техникийн зохицуулалт

Энэ бүлгээр техникийн зохицуулалт боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, мөн техникийн зохицуулалтын талаар Дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааны зохицуулалтыг тусгасан.

Техникийн зохицуулалтыг зөвхөн төрийн захиргааны төв байгууллага боловсруулдаг байсныг холбогдох төрийн захиргааны байгууллага боловсруулдаг болгож, хүрээ хязгаарыг нэмэгдүүлсэн.

Дөрөвдүгээр бүлэг. Тохирлын үнэлгээ

Энэ бүлгээр тохирлын үнэлгээний зорилго, хамрах хүрээ, тохирлын баталгааны хэлбэр, тохирлын үнэлгээний байгууллага, баталгаажуулалтын байгууллага, лаборатори, техникийн хяналтын байгууллагын эрх, үүрэг, үйл ажиллагааны үндсэн зохицуулалтыг тусгасан.

Тохирлын үнэлгээний байгууллагын эрх үүрэг, тохирлын үнэлгээний үр дүнг төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашигладаг байх, гадаад улсын тохирлын үнэлгээний байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тохирлын үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд тохирлын үнэлгээний итгэмжлэлийн байгууллагад бүртгүүлэх, бүртгүүлээгүй тохиолдолд үр дүнг хүлээн зөвшөөрдөггүй байх зохицуулалтыг тусгаж, лабораторийн шаталсан тогтолцоог тусгасан болно.

Тавдугаар бүлэг. Тохирлын үнэлгээний итгэмжлэл

Энэ бүлгээр тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зорилго, тогтолцоо, удирдлага, итгэмжлэлийн байгууллага, түүний Удирдах зөвлөл, техникийн хороо, маргаан шийдвэрлэх комисс болон итгэмжлэлийн шинжээчийн эрх, үүрэг, үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг тусгасан.

Зургадугаар бүлэг. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тогтолцоо, удирдлага

Энэ бүлэгт Засгийн газар, салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төрийн захиргааны төв байгууллага болон стандартчилал, техникийн

зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, иргэн хуулийн этгээд стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагаанд ямар эрх үүрэгтэй оролцох болон салбар дундын уялдаа холбоог хангах талаар зохицуулсан.

Долдугаар бүлэг. Стандартчилал, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн мэдээллийн нэгдсэн сан

Энэ бүлгээр стандартчилал, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн мэдээллийн нэгдсэн сангийн бүтэц, бүрдүүлэлт, хөгжүүлэлт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт болон мэдээллийн удирдлагын тогтолцоог зохицуулсан. Стандартчилал, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага, аж ахуйн нэгж холбогдох мэдээ мэдээллийг хэрэглэх, ашиглахаар тусгасан.

Мэдээллийн нэгдсэн сантай болсноор стандарт, техникийн зохицуулалтын мэдээллийг нэг эх сурвалжаас авах боломж бүрдэж, Стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, иргэн, хуулийн этгээд бизнес эрхлэгчдийн мэдээлэл авах хүртээмж нэмэгдэж, гадаад худалдаа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сайжирна.

Наймдугаар бүлэг. Санхүүжилт

Энэ бүлгээр стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр, улсын төсвөөс болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх зохицуулалтыг тусгасан.

Есдүгээр бүлэг. Хариуцлага

Энэ бүлгээр хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчил, гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар стандартыг хэрэглэх, хэрэглэхээр сонгосон стандартын үзүүлэлт шаардлагыг хангасан байх, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо, лабораторийн шатлал боловсронгуй болж, олон улсын нийтлэг жишигт нийцсэнээр дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг олон улсад зөвшөөрөх, гадаад худалдаа, экспортыг хөнгөвчлөх нөхцөл сайжирна. Түүнчлэн стандартын хэрэгжилт хангагдаж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

